

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2020-01-24

Тендер шалгаруулалтын нэр: Аймгийн төвийн нийтийн тээврийн 12 хүний суудалтай 2 эко автобус нийлүүлэх тендер

Тендер шалгаруулалтын дугаар: [ДУГАОНӨГ/202001021](#)

Дундговь аймгийн Орон нутгийн өмчийн газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос “Аймгийн төвийн нийтийн тээврийн 12 хүний суудалтай 2 эко автобус” нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу.

Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50.000,0 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн дундаж нь 100 сая төгрөгөөс багагүй

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 70 сая төгрөгөөс багагүй

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: сүүлийн 2 жил

Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: 100 сая төгрөгөөс багагүй

Тусгай зөвшөөрөл шаардлагагүй

Тендерийн хамт 1,000,000 төгрөгийн дүнтэй цахим тендерийн баталгааг цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Тендерийг 2020 оны 02-р сарын 28 ний өдрийн 10 цаг 00 минутаас өмнө цахим сиитемээр (www.tender.gov.mn) хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2020 оны 02-р сарын 28-ний өдрийн, 10 цаг 30 минутад нээнэ.

Гадаадын этгээд тендерт оролцох эрхтэй.

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээс авч болно.

Дундговь аймгийн
Орон нутгийн өмчийн газар 70593399, 90117199